

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ**  
**2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Багануур дүүрэг

№	ҮНДЭСЛЭЛ	ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
1.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2	<p>БҮТП-ийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах ажлын хүрээнд НЗДТГ-ын Лхамсүрэн мэргэжилтэнд дараах нэмэлт материалуудыг бүрдүүлэн цахимаар хүргүүлэв.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Анх паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байсан УУХҮЯ-тай хамтран ажилласан 4 жилийн гэрээний тайлан</li> <li>- Байгууллагын 2017-2020 оны үйл ажиллагаанд ХШҮХ-ээс хийгдсэн шалгалтын дүгнэлтүүд НЗДТГ холбогдох материалыг хавсарган албан бичгээр ХХААХҮЯ-нд паркийн тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг уламжилсан.</li> </ul>	100%
2.	БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл	<ul style="list-style-type: none"> <li>- 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугамын зураг төслийг гүйцэтгэгч Мон-Энержи Консалт ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй цахим хурал зохион байгуулж, Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоололыг нягталж хянаж, Паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтанд шаардлагатай санхүүжилтийн зардлын нарийвчилсан төсвийн саналыг Сангийн яамны холбогдох мэргэжилтний ERP хаягт хүргүүлсэн.</li> <li>- Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна.</li> <li>- Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугамын барилгын бүтээц, барилга архитектур, халаалт агаар сэлгэлт болон үндсэн дэд станц болох 110/35кВ-ын анхдагч хэлхээний зураг төсөл магадлангаар хянуулан баталгаажуулсан.</li> <li>- Дээрх 110/35кВ-ын дэд станцын хоёрдогч хэлхээ ба реле хамгаалалтын автоматын зураг төслийг ЦДҮС ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан батлуулахаар илгээсэн.</li> </ul>	100%

		- Паркийн үндсэн 110/35кВ-ын дэд станцаас Хүнд үйлдвэрлэлийн бүсэд байгуулагдах цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 35кВ-ын агаарын шугам болон 35/10кВ-ын төмөрлөг дэд станцын зураг төсөл Барилгын Хөгжлийн төвийн магадлангаар хянагдан баталгаажсан.	
3.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.1.4	Паркийн дэргэд байгуулах Инкубатор, инноваци, судалгааны төвийн барилгын засварын төсвийг гаргаж байна.	70%
4.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.1.5	Ковид-19 халдварын тоо нэмэгдэж, Паркийн анхны нэгж ШУУ-ийн Монхимо ХХК нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага гарсан тул хамтын ажиллагааны 2021-2022 оны төлөвлөгөөг 6 дугаар сард хамтран хэлэлцэхээр тогтов.	0%
5.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.2.2	<ul style="list-style-type: none"> <li>- Паркад хүнд үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх сонирхол илэрхийлсэн “МЗ” ХХК, “Тэмүүжин-Метал” ХХК-ийн саналуудыг цахимаар хүлээн авч, холбогдох дүгнэлт гарган зөвлөмж хүргүүлсэн.</li> <li>- Зөвлөмжийн дагуу “МЗ” ХХК нь Налайх ҮТП-д төслөө хүргүүлэн ажиллахаар болсон тухай мөн цахимаар манайд мэдээлсэн.</li> <li>- “Тэмүүжин-Метал” ХХК нь төсөлдөө байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон Техник технологийн түвшний нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр ажиллаж байгаа тухай мэдээлэл ирүүлээ.</li> </ul>	100%
6.	Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган чөлөөлөгдсөн 2, албан тушаал хавсран гүйцэтгэж байгаа 2 албан хаагчийн мэдээллийг 04 дүгээр сарын 01-ний өдөр ERP системд оруулж бүртгэлийг хийсэн.</li> <li>- 2021 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хариутай 7, хариугүй 6 нийт 13 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.08</li> <li>- 2021 оны 04 дүгээр сарын байдлаар “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 10 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%</li> </ul>	100%
7.	ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын цахим хуудсыг шинэчлэх ажил дуусах шатандаа байна.</li> <li>- 2021 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2, цар тахалтай холбоотой 10 мэдээллийг байршуулсан.</li> </ul>	80%
8.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын 2021 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлан, баланс гаргаж 04 дүгээр сарын 07-ны өдөр <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a> сайтаас илгээсэн.</li> <li>- <a href="http://www.shilendans.mn">www.shilendans.mn</a> сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж байна.</li> </ul>	100%

		- 2021 оны байгууллагын батлагдсан төсвийн хуваарийн дагуу 4 дүгээр сарын санхүүгийн орлого зарлагын гүйлгээг хугацаанд нь зохих журмын дагуу хийлгэсэн.	
9.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1	- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. - Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 10-25-ны өдрүүдэд ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 49 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хүний нөөцийн удирдлагын тасагт хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 104 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/313 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
<b>НЭМЭЛТ АЖИЛ</b>			
10.	НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 7 хоног тутам НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хүргүүлэн ажиллаж байна.		100%
11.	Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна.		100%
12.	Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгах "Шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж"-ийн санал авч байгаатай холбогдуулан саналыг хавсралт маягтын дагуу боловсруулж 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр nzdtghbth2020@gmail.com цахим хаягт илгээсэн.		100%
13.	eDoc, албан тушаалын систем дээрх ашиглагдахгүй байгаа, илүү үүсгэсэн, албан тушаалын нэр өөрчлөгдсөн хэрэглэгчийн мэдээллийг шинэчилсэн тухай мэдээг гарган дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-т 04 дүгээр сарын 26-ны өдрийн 55 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.		100%
14.	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын утасны жагсаалтыг шинэчилж байгаатай холбогдуулан байгууллагын дарга, ахлах мэргэжилтнүүдийн мэдээллийг 04 дүгээр сарын 28-ны өдрийн 56 дугаартай албан бичгээр дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн.		100%
15.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулж буй 4 модуль цахим хичээлийг албан хаагчдаар судлуулах ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 05-28-ны өдрүүдэд зохион байгуулж, илтгэх хуудсыг 04 дүгээр сарын 29-ний өдрийн 57 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.		100%
16.	Багануур дүүргийн ЗДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03/100 дугаартай албан бичгийн дагуу "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2021" сарын аяныг зохион байгуулсан тухай тайланг 04 дүгээр сарын 30-ны 59 дугаартай албан бичгээр дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлсэн.		100%
17.	Монгол Улсын 2022 оны төсвийн төслийн саналд паркийн Үйлдвэрийн албан конторын барилгын төсвийг нэмэлтээр тусган нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын холбогдох мэргэжилтний цахим хаягт 04 дүгээр сарын 22-ны өдөр хүргүүлсэн.		100%
18.	Сангийн яамны цахим системд байгууллагын 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн жагсаалтыг 04 дүгээр сарын 23-ны өдөр шивж дуусгасан.		100%

19.	Дүүргийн удирдах ажилтнуудын 2021 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн шуурхай зөвлөгөөн дээр дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу "Их цэвэрлэгээ-90 минут" цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, тайланг 04 дүгээр сарын 22-ны өдөр baganuurzaa@gmail.com хаягаар болон дүүргийн ЗАА-нд 54 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлэв.	100%
20.	НЗДТГ-ын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 03/1696 дугаартай албан бичгийн дагуу Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга сэдэвт сургалтанд паркийн дарга, ахлах мэргэжилтэн нарын хамт 04 дүгээр сарын 29-ний өдөр хамрагдав.	100%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч. ЭЛБЭГСАЙХАН



БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:  
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗАЯА